



**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО**

Улаанбаатар  
2023 он

## **ЗОРИЛГО**

Энэхүү бодлогын зорилго нь БИД ББСБ-ын стратегийн зорилго зорилттой нийцсэн, тэдгээрийн харилцагчийн мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал, бизнесийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, мэдээллийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоог бий болгох арга замаар мэдээллийн аюулгүй байдлыг удирдахад оршино.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Байгууллага нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандартад нийцсэн байна.

## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗОРИЛТУУД**

Мэдээллийн аюулгүй байдлын засаглал нь мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагааг иж бүрэн, нэгдмэл байхыг баталгаажуулдаг байна.

**Зорилт 1:** Байгууллагын хамрах хүрээнд мэдээллийн аюулгүй байдлыг бий болгох

**Зорилт 2:** Шийдвэр гаргахдаа эрсдэлд суурилсан арга барилыг хэрэгжүүлэх

**Зорилт 3:** Гадаад болон дотоод шаардлагуудад нийцтэй байдлыг хангах

**Зорилт 4:** Оролцогч талуудын хүлээлт, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллахыг зорино.

**Зорилт 5:** Мэдээллийн аюулгүй байдлын орчныг бүрдүүлж даган мөрдөж засан сайжруулахыг зорино.

**Зорилт 6:** Одоогийн болон ирээдүйн бизнес шаардлагуудад нийцүүлэн гүйцэтгэлийг хянах.

**Зорилт 7:** МАБ-ын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй байлгахын тулд байгууллагын бүх ажилтан болон гуравдагч байгууллага, түнш, харилцагчдад мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулахаар мэдээлэл зөвлөмж өгч ажиллана.

## **МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАСАГЛАЛЫН ПРОЦЕСС**

Мэдээллийн аюулгүй байдлын засаглалын үндсэн дөрвөн процесс болон удирдлагын багийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон.

**Процесс 1: Үнэлэх** процесс нь одоогоор хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төлөвлөгдсөн өөрчлөлтүүд дээр үндэслэн одоогийн болон хүрэхийг зорьж буй зорилтуудад ямар зохицуулалт хийх шаардлагатайг тодорхойлдог засаглалын процесс юм.

**Процесс 2: Чиглүүлэх** процесс нь байгууллагын стратеги зорилтуудын тухай чиглэлийг өгдөг засаглалын процесс юм. Тухайн чиглүүлэгт байгууллагын нөөцүүдийн хуваарилалт, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшин, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө багтана.

**Процесс 3: Байнгын хяналт** процесс нь байгууллагын стратегийн зорилтууддаа хүрэхийг үнэлэх боломжийг олгодог засаглалын процесс юм.

**Процесс 4: Харилцаа** процесс нь удирдах байгууллага болон сонирхогч талууд өөрсдийн хэрэгцээнд тохирсон мэдээлэл солилцдог хоёр талын засаглалын үйл явц юм.